Всего уголовно-исполнительным законодательством Республики Казахстан определено 6 степеней поведения осужденного (три отрицательных и три положительных) достижению каждой из которых должно сопутствовать выполнение осужденным определенных условий: наличие поощрений и отсутствие взысканий за определенный временной период, членство в добровольной организации осужденных (для положительных степеней), признание осужденного нарушителем, систематическим нарушителем либо злостным нарушителем

установленного порядка отбывания наказания (для отрицательных степеней). Необходимо отметить, что при отсутствии у осужденного поощрений и непогашенных взысканий он будет считаться не имеющим определенной степени исправления.

Несмотря на то, что рассматриваемый институт подвергался конструктивной критике со стороны казахстанских ученых-пенитенциаристов, он образует эффективную систему критериев оценки степеней исправления.

Стоит отметить, что схожие положения отражены в ст. 116 УИК Республики Беларусь. Указанная норма закрепляет три степени исправления осужденного, признание которых необходимо для реализации его законных интересов: ставший на путь исправления, твердо ставший на путь исправления и доказавший свое исправление по отбытии не менее одной четверти срока наказания. Каждой степени соответствует указанный в положениях ч. 3, ч. 4, ч. 5 ст. 116 УИК Республики Беларусь перечень формальных и материальных оснований, несколько отличающихся от критериев оценки степени исправления, регламентированных УИК Республики Казахстан (письменное обязательство о правопослушном поведении, отсутствие взысканий, добросовестное отношение к труду или учебе, выполнение различных видов работ по благоустройству исправительного учреждения, проявление полезной инициативы и др.). Следует отметить, что положения данной нормы обнаруживают тождественность с системой степеней исправления, существовавших в ИТК РСФСР 1970 года.

Несмотря на вопросы, возникающие при научной оценке эффективности рассматриваемого института в других странах, допустимость включения его аналога в российское законодательство рассматривалась в различное время и поддерживалась отечественными учеными-пенитенциаристами.

Так, И.Я. Янчук отмечает, что «отсутствие четкой правовой регламентации влечет оценку осужденного комиссией исходя из интересов, зачастую не связанных с достижением целей наказания». И.А. Смирнов, говоря об отсутствии разработки и систематизации оценки степени исправления осужденных, отмечает, что указанное обстоятельство «не только затрудняет реализацию прогрессивной системы отбывания наказания, но и приводит к отсутствию единообразной судебной практики

применения соответствующих норм уголовно-исполнительного законодательства». Кроме того, автор отмечает необходимость закрепления перечня степеней исправления осужденных, так как в противном случае происходит формирование оценочно-правовой коллизии, где на основании одинаковых критериев исправления могут быть предоставлены совсем различные социально-правовые последствия.

Соглашаясь в определенной мере с представленной позицией, мы считаем, что отечественному законодателю следовало бы рассмотреть возможность закрепления в УИК РФ перечня степеней исправления осужденных, а также критериев их определения, взяв за основу положительный опыт советского исправительно-трудового законодательства, а также уголовно-исполнительного законодательства Республики Казахстан и Республики Беларусь.

Список литературы:

1. Горбань Д.В. Правовое регулирование проживания осужденных за пределами исправительных учреждений :дис. … канд. юрид. наук. Рязань, 2014.

2. Кашуба Ю.А. Гармонизация уголовно-исполнительного законодательства как основа взаимодействия уголовно-исполнительных систем стран Евразийского экономического союза // В сборнике: Преступление, наказание, исправление сборник тезисов выступлений и докладов участников IV международного пенитенциарного форума : (к 140-летию уголовно-исполнительной системы России и 85-летию Академии ФСИН России) : в 10 т.. Рязань, 2019.

3. Скаков А.Б. Об оценке поведения осужденных, лишенных свободы // Уголовно-исполнительное право. 2018. Т. 13. № 2. С. 116–123.

4. Смирнов И.А. Критерии исправления положительно характеризующихся осужденных по законодательству стран СНГ (Россия, Казахстан, Белоруссия) // Вестник Нижегородского университета им. Н.И. Лобачевского. 2019. № 3. С. 134-142.

5. Стурова М.П., Первозванский В.Б. Педагогические основы профессиональной деятельности сотрудников исправительных учреждений : метод. Пособие. – М : НИИ ФСИН России, 2005. С. 33. (123 с.).

6. Финаева А.Г. Ресоциализационный потенциал семьи осужденного // ИСОМ. 2012. №4. С. 175-176.

7. Янчук И.А. Об использовании оценки степени исправления осужденных к лишению свободы в процессе дифференциации и индивидуализации // Вестник института: преступление, наказание, исправление. 2016. № 1 (33). С. 50–53.

ЦАГДАН ХОРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ



Б.БАТЗАЯА
ШШГЕГ-ын харъяа Ховд аймаг дахь ШШГГ 457 дугаар нээлттэй хаалттай хорих ангийн ээлжийн дарга,
ахлах дэслэгч

Товч агуулга: Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний тухай ойлголт, онцлог, эрх зүйн зохицуулалт, цагдан хорих ажиллагаанд тулгамдаж буй өнөөгийн зарим асуудал

Abstract: The concept of provisional detentions and prevention,some current issues facing to actions provisional detentions, about their features and legal regulations.

Түлхүүр үгс: Цагдан хорих шийдвэр нь таслан сэргийлэх арга хэмжээний нэг төрөл болох нь

Key words: The concept of provisional detentions and prevention,some current issues facing to actions provisional detentions, about their features and legal regulations.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа гэм буруу үйлдэл хийсэн нэгнээ хорьж, шийтгэж ирсэн ба түүхийн явцад улам бүр боловсронгуй болон хөгжиж ирсэн. Хорьж мөрдөх асуудал нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан байдаг тул хууль, эрх зүйд улам бүр баяжиж төгөлдөршиж ирсэн байдаг.

Хүний эрх эрх чөлөөг хязгаарлах нь хууль зүйн шинжлэх ухаанд “албадлага” гэж нэрлэгдэн өдгөө хүртэл судлагдсаар ирсэн. Нийгмийн харилцааны ямар хэлбэрийг зохицуулж байгаагаасаа хамаарч эрх зүйн албадлага нь харилцан адилгүй ойлголт, судлагдахуун, зорилготой байдгийг судалсаар байна. Хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшин, нийгмийн харилцааны хурд зэрэг зүйлээс хамаарч ойлголт нь янз бүрээр өөрчлөгдсөөр ирсэн. Тэр дундаа эрүүгийн процессын албадлага нь амьдралд үйлдэгдсэн аливаа гэмт хэргийн бодит үнэнийг тогтоох, хөдөлбөргүй нотлох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэлийг шударгаар

оногдуулах зорилготой нягт холбоотой учраас цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг улам бүр боловсронгуй болгох шаардлага байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй “Хорих байрны дотоод журам” нь хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн батлагдсан. Энэхүү журам нь 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн зүйл заалтыг удирдлага болгодог.

“Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийг баталснаас хойш манай байгууллагын түүхэн хөгжил, цаг үеийн нөхцөл байдал, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2000 оны 02 дугаар сар, 2002 оны 01 дүгээр сар, 2013 оны 12 дугаар сар, 2017 оны 05 дугаар саруудад тус тус нэмэлт өөрчлөлт орж байсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдсантай холбогдуулан, нийцүүлж 2002 онд томоохон өөрчлөлт орсон ба тэр цагаас хойш эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2017 онд мөн томоохон өөрчлөлт оруулж байсан. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулж түүнд нийцүүлэн гаргадаг бусад эрх зүйн актуудыг өөрчлөн найруулсан байдаг.

Энэхүү өгүүллийн гол зорилго нь Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан хорих байрны дотоод журам нь хууль тогтоомжид нийцэхгүй өөрчлөх шаардлагатай талаар өгүүлэх болно.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийг шинэчлэн найруулж түүнд нийцүүлэн гаргадаг бусад эрх зүйн актуудыг өөрчлөн найруулсан байдаг. Гэвч хууль зүйн сайдын баталдаг хорих байрны дотоод журам нь 2014 оны 11 дүгээр сараас хойш шинэчлэн батлаагүй байгаа нь зарим зүйл заалтууд амьдрал болон хуульд нийцэхгүй байна. Ингээд хууль болон амьдралд нийцэхгүй байгаа заалтуудын талаар эсээний үндсэн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний тухай ойлголт

Цагдан хорих нь бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй харьцуулахад яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг их хэмжээгээр хязгаарладаг хамгийн хатуу арга хэмжээ юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын

Пактын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчилж цагдан хорьж болохгүй” Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж тус тус заасан нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн баталгаа юм. Тийм ч учраас ЭХХШ тухай хуульд цагдан хорих үндэслэл, журмыг нарийвчлан хуульчилжээ.[1]

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхэд онцгой шаардлага тавигдаж байгаагийн нэг илрэл бол түүнийг хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, удаа дараа ял шийтгэгдэж байсан яллагдагч, шүүгдэгчид хэрэглэж буй өнөөгийн практик.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь яллагдагч, шүүгдэгчийн хувийн эрх, эрх чөлөөг их хэмжээгээр хязгаарладаг тул түүнийг хэрэглэх тусгай нөхцөлийг хуулиар тогтоож өгчээ.

Шүүх ЭХХШ тухай хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан ёсоор яллагдагч:

- ЭХХША-наас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;

- Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

- Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

- Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл бүрдэнэ.[2]

Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.[3]

---

[1] “Ж.Бямбаа”, “Ж.Эрхэсхулан” Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018. 142 дахь тал

[2] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017. №23

[3] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016. №7

Яллагдагчийн цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байна.

Хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол шүүх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.[4]

Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/, 19.6/Хорлон сүйтгэх/, 29.5/Төрлөөр устгах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно.

Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, суллагдсан яллагдагчид урьд нь цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглоно.

Өсвөр насны яллагдагч, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй яллагдагч, жирэмсэн яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан үндэслэлээр, эсхүл урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч болно.[5]

1. **Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай**

Хорих байрны дотоод журам

Хорих байранд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг дагаж мөрдөнө.

---

[4] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017. №23. 11 дэх тал

[5] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017. №23. 12 дахь тал

Хорих байрны дотоод журмаар дараах асуудал зохицуулна:

- Хоригдох этгээдийг хүлээн авах, хорих өрөөнд байрлуулах;
- Хоригдсон этгээдэд хориглох зүйл;
- Хоригдсон этгээдэд өгөх цай, хоолны хэмжээ, хоригдол тус бүр хоолоо идэж байгаа эсэхэд хяналт тавих;
- Хоригдсон этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийх;
- Хоригдсон этгээдийг эргэх, түүнтэй уулзах;
- Хоригдсон этгээд захидал, цахилгаанаар харилцах;
- Хоригдсон этгээд ном, сонин, сэтгүүл ашиглах;
- Хоригдсон этгээд шашны зан үйл үйлдэх;
- Хоригдсон этгээдийн эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээ;
- Хоригдсон этгээдийг салхилуулах;
- Хоригдсон этгээдийг мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд оруулах, буцаан авчрах;
- Хорих өрөөнд гаднаас хүн ороход түүний аюулгүй байдлыг хангах.
- Хорих байрны дотоод журамд хоригдсон этгээд хорих өрөөнд авч орж болох гутал, хувцас, бусад хэрэгцээтэй зүйл, түүнчлэн төлбөртэй үйлчилгээний төрлүүдийг тодорхой тусгана.[6]

Хоригдсон этгээдийн эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх

Хоригдсон этгээд дараах эрх эдэлнэ:

- Өөрийн эрх, үүрэг, хорих байрны дотоод журам, өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхийн талаар мэдээлэл, тайлбар авах;
- Өөрийн хувийн аюулгүй байдлыг хангуулах;
- Хорих байрны дарга болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих байранд ажиллах үеэр нь хувиараа уулзах;
- Өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах;
- Ар гэр бүлтэйгээ уулзах;
- Улсын нууцтай холбоотой болон гэмт үйлдэлд холбогдолтой урвуулан ашиглаж болзошгүйгээс бусад, өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах;
- Ном, сонин, сэтгүүл, ариун цэврийн хэрэгсэл өрөөндөө байлгах;

[6] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1999он. №34

- Энэ хуулиар тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах;
- Шөнийн цагт 8 цагаас багагүй хугацаагаар унтаж амрах;
- Эмнэлгийн тусламжийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан журмын дагуу авах;
- Хорих байрны дотоод журамд заасны дагуу захидал, цахилгаанаар харилцах, бичгийн хэрэгсэл ашиглах;
- Хорих байрны дотоод журам зөрчихгүйгээр шашны зан үйл үйлдэх;
- Хорих байрны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах; боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном ашиглах;
- Эргэлт авах;
- Иргэний эрх зүйн хэлцэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;
- Өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах.

Хоригдсон этгээд дараах үүрэгтэй:

- Хорих байрны дотоод журмыг чанд сахиж, хорих байрны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сахих;
- Хорих байрны ажилтныг ажил, үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахгүй байх;
- Хуурамчаар өвчилсөн, эрүүл мэнд болон бие эрхтэндээ санаатайгаар хохирол, гэмтэл учруулсан бол эмчилгээний зардлыг хувиасаа төлөх;
- Хорих байрны эд зүйлийг эвдэж гэмтээх, нууцаар худалдаа, наймаа хийх зэрэг зөрчил гаргахгүй байх.
- Хоригдсон этгээд өмгөөлөгч болон төрөл садан, бусад хүмүүстэй уулзах
- Хоригдсон этгээд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно. Хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах нөхцөлөөр хангагдсан байна.
- Хоригдсон этгээдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны буюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр

олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзуулж болно.

- Хоригдсон гадаад улсын иргэн нь албан тушаалтны зөвшөөрлөөр хорих байрны захиргаагаар дамжуулан өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтантай уулзаж болно.
- Хоригдсон этгээд төрөл садан болон бусад хүмүүстэй уулзахад хорих байрны харуул хамгаалалтын ажилтан байлцана. Хориглосон хүнсний болон бусад зүйл, эсхүл гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулах буюу гэмт хэрэг үйлдэхэд хүргэх мэдээлэл дамжуулахыг оролдсон тохиолдолд уулзалтыг нэн даруй таслан зогсооно.
- Хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгөө уулзахад эргэлт уулзалтын журам хамаарахгүй.[7]

Хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг хангах

Хоригдсон этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан, хоригдсон бусад этгээдийн зүгээс түүнд заналхийлсэн, довтолсон тохиолдолд хорих байрны ажилтан хоригдсон этгээдийн хувийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ цаг алдалгүй авах үүрэгтэй.

Захидал, харилцаа

Хоригдсон этгээд төрөл садан болон бусад хүмүүстэй зохих журмын дагуу захидал, цахилгаанаар харилцах бөгөөд зардлыг өөрөө хариуцна.

Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана. Гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад болохуйц утгатай нууц үг хэллэг, шифртэй, төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцтай холбоотой захидал, цахилгааныг хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд шилжүүлнэ.

Хоригдсон этгээд нь ял эдэлж байгаа хүмүүстэй захидал, цахилгаанаар харилцахад зөвхөн хорих шийдвэр гаргасан албан тушаалтны зөвшөөрлийг үндэслэнэ.

Хоригдсон этгээдийн нэр дээр ирсэн захидал, цахилгааныг хорих байрны захиргаа хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор хүлээлгэн өгөх ба гадаад хэл дээрх захидал, цахилгааныг монгол хэлэнд орчуулахад шаардлагатай хугацааг энэ хугацаан дээр нэмж тооцож болно.

Хоригдсон этгээдийн ойрын төрөл, садны хүн хүнд өвчтэй байгаа, эсхүл нас барсан тухай мэдээг түүнд нэн даруй хүргэнэ.

[7] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1999он. №34

Хорих байрнаас суллагдсан этгээдийн нэр дээр ирсэн захидал, цахилгааныг хорих байрны захиргаа хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор хаягаар нь илгээнэ.

Өргөдөл, гомдол гаргах

Хоригдсон этгээд нь төрийн болон нутгийн захиргаа, бусад байгууллага, албан тушаалтанд явуулах өргөдөл, санал, гомдлоо хорих байрны захиргаагаар дамжуулан илгээнэ.

Шүүх, прокурор болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий төрийн бусад байгууллагад явуулах өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж шалгаж болохгүй бөгөөд өргөдөл, санал, гомдлыг хүлээн авсан өдрийн дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр битүүмжилсэн дуттуйгаар зохих байгууллагад илгээнэ.

Төрийн байгууллага, албан тушаалтанд хаягласан өргөдөл, санал гомдлыг хорих байрны захиргаа хянаж, хүлээн авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор илгээнэ.

Гэмт хэргийн бодит үнэн тогтооход саад болохуйц утгатай, нууц үг хэллэг, шифртэй төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцтай холбоотой өргөдөл, санал, гомдлыг хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд шилжүүлнэ.

Мөрдөгч, прокурорын үйл ажиллагаатай холбогдолтой гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор холбогдох байгууллагад нь илгээнэ.

Өргөдөл, санал, гомдлын хариуг хоригдсон этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт нь хавсаргана.

Өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалуулахаар өргөдөл, санал, гомдол гаргасан хоригдож буй этгээдийг хавчин хяхах, мөрдөн мөшгөхийг хориглоно. Ийнхүү хавчин хяхсан, мөрдөн мөшгөсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хоол хүнс болон нэн хэрэгцээтэй зүйлээр хангах

Хоригдсон этгээд нь өдөрт 3400 килокалори (ккал)-аас дээш хэмжээний илчлэгтэй хоолоор үнэ төлбөргүй хангагдана.

Хоригдсон этгээд нь хүнсний болон нэн хэрэгцээтэй зүйлээ бэлнээр худалдан авч хэрэглэх эрхтэй.

Ахуйн хангамж

Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана.

Хорих байрны өрөө нь нэг хүнд 2,5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна.

Хорих байр нь агааржуулах төхөөрөмжтэй байна.

Хоригдсон этгээдэд хорих байрны захиргаанаас хучлага, дэвсгэр, аяга, халбага тавьж олгоно.

Хоригдсон этгээд нь аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад ном, сонин, сэтгүүлийг хорих өрөөндөө байлгаж болно.

Эмнэлэг, эрүүл ахуйн хангамж

Хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, халдваргүйжүүлэх ажлыг эрүүл мэндийг хамгаалах холбогдох хууль тогтоомжид заасны дагуу явуулна. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй.

Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн ажилтан ирж, үйлчлэх журмыг эрүүл мэнд, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

Хоригдсон этгээд биедээ гэмтэл авсан тохиолдолд хорих байрны эмнэлгийн ажилтан эмнэлгийн үзлэг хийж, үзлэгийн дүнг гэмтэл авсан этгээдэд танилцуулж, энэ тухай хувийн хэрэгт тэмдэглэнэ. Хорих байрны даргын болон мөрдөгч, прокурорын санаачилгаар, эсхүл гэмтэл авсан этгээд, түүний өмгөөлөгчийн хүсэлтээр үзлэгийг эмнэлгийн ердийн байгууллагаар хийлгэж болно.

Хоригдсон этгээд хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан тохиолдолд хорих байрны захиргаа нь түүний ойрын төрөл садан болон хорих шийдвэр гаргасан албан тушаалтан, прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

Хоригдсон этгээд нас барсан тохиолдолд цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийсний дараа ар гэр, төрөл садны хүмүүст шилжүүлнэ. Цогцсыг ирж авах хүнгүй бол тухайн хорих байрны зардлаар оршуулна.[8]

Хорих байрны дотоод журам

Журмын 2.2-д “Хорих байр нь хоригдох этгээдийг нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу 08.00-18.00 цагийн хооронд хүлээн авах ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.10 дахь хэсэгт заасан

[9] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1999он. №34

үндэслэлээр нэг хорих байрнаас нөгөө хорих байранд шилжүүлэхээс бусад тохиолдолд хорих байранд нутаг дэвсгэрийн харьяаллын бус хоригдох этгээдийг хүлээн авахыг хориглоно” гэж заасан байдаг.

“Хоригдох этгээдийг нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу 08.00-18.00 цагийн хооронд хүлээн авна” гэсэн заалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай байх зарчим алдагдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим

4.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримтална.[9]

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.10 дахь хэсэгт заасан үндэслэлээр нэг хорих байрнаас нөгөө хорих байранд шилжүүлэхээс бусад тохиолдолд хорих байранд нутаг дэвсгэрийн харьяаллын бус хоригдох этгээдийг хүлээн авахыг хориглоно” гэж заасан байдаг. Энэ заалт нь 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар бүхэлдээ хүчингүй болсонд тооцсон хуучин эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэр томьёо ашигласан байдаг.

Хүчингүй болсон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалт

~~68.10.Сэжигтэн, яллагдагчийг оор газарт шилжүүлэн цагдан хорих эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүгч захирамж гарган шийдвэрлэх бөгөөд хэрэв шүүх шилжүүлэн хорих саналыг хүлээн авсан бол энэ тухай сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүн, эсхүл өмгөөлөгчид 24 цагийн дотор мэдэгдэнэ.~~

Хорих байрны дотоод журмаас

2.7.Согтууруулах ундааны зүйл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэсэн хоригдох этгээдийг хорих байранд саадгүй хүлээн авч тусгай өрөөнд байршуулна. Хэрэв хоригдох этгээдэд хорих байрны эмнэлгийн шатлалаас дээш шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүлээн авахгүй.

2.8.Энэ журмын 2.7-д заасан хоригдох этгээдийг хүлээн авахгүй нөхцөл үүссэн үед хорих байрны жижүүр, цагдан хорих байрны эмч энэ талаар тэмдэглэл үйлдэж, цагдан хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан

[9] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он. №24

тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ. Хүлээн авч болохгүй нөхцөл байдал арилсан үед хоригдох этгээдийг хүлээн авна” гэж заасан байдаг.

“Хэрэв хоригдох этгээдэд хорих байрны эмнэлгийн шатлалаас дээш шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүлээн авахгүй. Хүлээн авч болохгүй нөхцөл байдал арилсан үед хоригдох этгээдийг хүлээн авна” гэх заалт ойлгомжгүй байна. Хүлээн авч болохгүй нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд ямар байгууллага хариуцах, ямар үйл ажиллагаа явагдах нь тодорхойгүй байна.

18.1.Мөрдөн байцаах, шүүх хуралдааны ажиллагаанд хоригдсон этгээдийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бичгээр ирүүлсэн баримтыг үндэслэн оролцуулах ба тэдгээрийг хуяглан хүргэх, буцаан авч ирэх, харуул хамгаалалтын ажиллагааг Тахарын алба гүйцэтгэнэ.

20.4-д “Тахарын алба шүүхэд хуяглан хүргэх хоригдогч нарын тоог тухайн хорих ангийн удирдлагад 1 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэн байна” гэж татан буугдсан байгууллагын нэр ашигласан байна. “Хорих ангийн удирдлагад мэдэгдэнэ” гэснийг хорих байрны дарга болгон өөрчлөх шаардлагатай.[10]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

14.9 дүгээр зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

1.Шүүх дараах үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргана:

1.1.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;

1.2.шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.3.гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

1.4.урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.[11]

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн

[10] “Хорих байрны дотоод журам” 2014 он

[11] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он, №23

яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.[12]

Дүгнэлт

Хорих байранд хоригдох этгээдийг 08.00-22.00 цагийн хооронд хүлээн авах гэснийг 08.00-22.00 цаг болгон өөрчлөх

Эрүүгийн байцаан шийтгэх хууль гэснийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болгон өөрчлөх

“Хэрэв хоригдох этгээдэд хорих байрны эмнэлгийн шатлалаас дээш шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүлээн авахгүй. Хүлээн авч болохгүй нөхцөл байдал арилсан үед хоригдох этгээдийг хүлээн авна” гэх заалт ойлгомжтой болгох, Хүлээн авч болохгүй нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд ямар байгууллага хариуцах, ямар үйл ажиллагаа явагдахыг тодорхой болгох.

Тахарын алба гэснийг цагдаагийн байгууллага болгон өөрчлөх

ХАВСРАЛТ

Хүснэгт 1

[12] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2017 он, №7



БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН НИЙТ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧДЫН ТОО

Хүснэгт 2 /Бүс, аймаг, нийслэлээр, жилээр/[13]

Аймаг	**Аймгийн код**	**2018 он**	**2019 он**	**2020 он**
Улсын дүн	0	16,389	17,110	16,667
Баруун бүс	**1**	**1,172**	**1,316**	**1,326**
Баян-Өлгий	183	281	287	366
Говь-Алтай	182	144	166	155
Завхан	181	194	192	222
Увс	185	238	257	187
Ховд	184	315	414	396
Хангайн бүс	**2**	**2,471**	**2,494**	**2,238**
Архангай	265	327	368	359
Баянхонгор	264	396	441	400

[13] www.1212.mn Хандалт, 2021.09.30

Булган	263	261	306	260
Орхон	261	540	511	421
Өвөрхангай	262	492	421	338
Хөвсгөл	267	455	447	460
Төвийн бүс	**3**	**2,783**	**2,718**	**2,504**
Говьсүмбэр	342	124	103	130
Дархан-Уул	345	600	616	470
Дорноговь	344	344	381	256
Дундговь	348	183	130	149
Өмнөговь	346	381	379	385
Сэлэнгэ	343	623	558	426
Төв	341	528	551	688
Зүүн бүс	**4**	**1,085**	**1,382**	**1,205**
Дорнод	421	397	414	426
Сүхбаатар	422	275	346	331
Хэнтий	423	413	622	448
Улаанбаатар	5	8,844	9,195	9,388

СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН НИЙТ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧДЫН ТООН СУДАЛГАА[14]

Хүснэгт 3 /Аймаг, нийслэлээр, жилээр/

[14] www.1212.mn Хандалт, 2021.09.30



Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. “Ж.Бямбаа”, “Ж.Эрхэсхулан” Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018. 142 дахь тал
2. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2017. №23
3. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016. №7
4. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1999он. №34
5. www.1212.mn хандалт

ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ



Б.БАТЧИМЭГ
Хуульч,
Хууль зүйн докторант

Хураангуй Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гуравдагч этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судлах, тохиолдол кейст дүн шинжилгээ хийх замаар тулгамдсан асуудлыг олж тогтооход энэхүү судалгааны зорилго оршино.

Abstract: The purpose of this study is to study the legal regulation of third-party payments in civil enforcement proceedings and to identify problems through case studies.

Түлхүүр үг: Гуравдагч этгээд, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, төлбөр гаргуулах ажиллагаа, хууль этгээд, иргэн, гэр бүлийн гишүүн, хувьцаа эзэмшигч, төлбөр төлөгч, төлбөр авагч

Key words: Tirth parties’ persons, court decision execution on civil, payment process, legal entities, citizen, family member, shareholder, payee, payer

Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” мөн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд шүүхээс гаргасан шийдвэрийн хэрэгжилт чухал үүрэгтэй байдаг.

Шүүхийн шийдвэр бүрэн, бодитой биелэснээр нэг талаас гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага ногдуулах, нөгөө талаас тэрхүү гэм буруутай үйлдлийн улмаас төр, иргэн, байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх боломж бүрддэг. Нөгөө талаасаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж, уг ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхгүй байх ёстой. Энэ нь нийгэмд шударга ёсыг тогтоох үндэс билээ.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна. Энэхүү сэдвийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг оролцогч болох гуравдагч этгээдийн эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудлыг гарган ирэхийг зорилоо.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь гуравдагч этгээдийн ойлголт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна[1]. Үүнд:

1. Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр;

2. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж;

3. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;

4. Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр;

5. Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;

6. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж зэрэг болно.

Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэргийн тоо жил бүр нэмэгдэж байгаа нь 2020 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэсэн хэргийн тооноос харж болно. Тухайлбал 2020 онд 53578

[1] , Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг https://legalinfo.mn/main/detail/12701

хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 23.7 хувиар өсчээ.[2]

Үүний зэрэгцээ иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцож буй гуравдагч этгээдийн тоо өсөн нэмэгдэж тэдний эрх ашиг хөндөгдөх, үүнтэй холбоотой гомдол, нэхэмжлэл гаргаж байгаа нь гүйцэтгэлийн ажиллагааг удаашруулах хүчин зүйл болж байна. Учир нь практикт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч төлбөр төлөгчтэй хамаарал бүхий гуравдагч этгээдээс төлбөр барагдуулах хуулийн заалтыг талууд өөр өөрийн байр сууринаас тайлбарлан нэг мөр ойлгохгүй байгаа нь дээрх нөхцөл байдлыг бий болгож байна.

Энэхүү асуудлыг авч үзэхийн өмнө иргэний процессын ажиллагааны оролцогч “гуравдагч этгээд” гэдгийг тодорхойлох нь зүйтэй. Академич, доктор, профессор С.Нарангэрэл “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд бусад этгээдийн үүсгэсэн иргэний хэрэгт хуулиар хамгаалагдсан өөрийн эрх ба ашиг сонирхолыг хамгаалж байгаа этгээд”[3] хэмээн онолын талаас нь тодорхойлсон байна.

Хууль зүйн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулинд зааснаар “Хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхээс иргэний хэрэг үүсгэгдсэн хэрэгт өөрийн санаачлагаар эсвэл шүүхийн шийдвэрээр оролцож байгаа этгээдийг хэлнэ.” [4]

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “Нэхэмжлэлийн шаардлагад тодорхойлсон захиргааны акт, захиргааны гэрээний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг гуравдагч этгээд гэнэ”[5] хэмээн тодорхойлсон.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд гуравдагч этгээд гэдгийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж байгаа төлбөр төлөгч болон төлбөр авагчаас бусад этгээдийг ойлгоно.” гэж Улсын дээд шүүхийн /УДШ/ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг

---

[2] Монгол улсын шүүхийн тайлан 2020 он, 220-р тал https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view,

[3] С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. 4 дэх хэвлэлт, УБ хот. 2015 он.

[4] http://www.supremecourt.mn/act/print/65, Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2010 оны №2

[5] https://legalinfo.mn/main/detail/11703, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

тайлбарлах тухай” 2007 оны 47 дугаар тогтоолын 8 дугаар зүйлд тайлбарлажээ.

УДШ-ийн тайлбараас харвал Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гуравдагч этгээд гэдэгт төлбөр төлөгчийн гэр бүлийн гишүүд, төлбөр төлөгч хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч хамаарахаар байна.

Гуравдагч этгээдийн зөрчигдөж буй эрхийн талаар

Төлбөр *төлөгч иргэний хувьд* “Гэр бүлийн гишүүд гэдэгт гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг”[6] ойлгоно. Харин хуулийн этгээд нь өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ.[7]

Хуулийн этгээдийг зорилгоор нь ашгийн болон ашгийн бус гэж ангилах бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээдэд компани, нөхөрлөл хамаарах бол ашгийн төлөө бус байгууллагад төрийн бус байгууллага, шашны байгууллага, сан, хоршоо хамаарна.

Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны явцад “гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй тохиолдолд дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд оногдох хэсгээс төлбөр гаргуулна” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.6-д заажээ. Энэхүү ажиллагааг гүйцэтгэхдээ мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-г үндэслэн явуулахаар хуульчилжээ. Хахин уг хууль заасан битүүмжлэх ажиллагаа нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх эд хөрөнгийг захиран зарцуулах, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлаж байна гэж үзэх үндэслэлтэй.

Энэ нь тухайн төлбөр төлөгчийн гэр бүлийн гишүүдийн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Монгол Улсын иргэн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” мөн хуулийн 16.13-т заасан “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй ... орон байрны халдашгүй байдлыг хуулиар

[6] https://legalinfo.mn/main/detail/226, Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэг

[7] https://legalinfo.mn/main/detail/299, Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

хамгаална”, 16.14-т заасан “...Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэсэн иргэний үндсэн эрхийг хөндөж байна хэмээн үзэж болно.

Гэвч төлбөр төлөгч иргэний дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь Үндсэн хууль заасан иргэний үндсэн эрхийг хөндөж байгаа хэдий ч тухайн иргэн хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг хязгаарлаагүй юм. Гагцхүү шүүхэд хандан хэрэг маргаан шийдвэрлүүлэх үйл явц нь цаг хугацаа шаардсан, эдийн засаг, сэтгэл санааны ихээхэн хохиролыг бий болгодог. Нөгөө талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг буруулах үр дагаварыг бий болгодог төдийгүй төлбөр авагчийн эрх хөндөгддөг. Иймд иргэний Үндсэн хуулинд заасан үндсэн эрхийг зөрчихгүй байх үүднээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны хувьд хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн эрхийн асуудал хөндөгдөж байдаг.

Төлбөр төлөгч *хуулийн этгээдийн хувьд* Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4-т “Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ” гэжээ.

Энэ хуульд заасан хууль тогтоомж гэдэгт “Компанийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг ойлгох бөгөөд үүнд заахдаа “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэжээ. Харин Улсын дээд шүүхийн 2007 оны 27 дугаар тогтоолоор үүнийг “компанийн хүлээх үүргийг гишүүн өөрийн өмчлөлийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээр хариуцахгүй бөгөөд гагцхүү компанид оруулсан хөрөнгө буюу эзэмшиж байгаа хувьцаагаар хариуцлага хүлээнэ” гэж тайлбарласан байна.

Хувьцаа гэдэг нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг

тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй[8] юм. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэжээ.

Компанийн хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь оруулсан хувь хэмжээгээрээ компанийн хөрөнгөд бүртгэгдэж, санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдах ёстой. Тиймээс тухайн хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө компаний үндсэн хөрөнгөөр бүртгэгдэж, хувь хүний өөрийн эзэмшлийн хөрөнгөнөөс нь зааглагдана. Өөрөөр хэлбэл оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээх хуулийн зохицуулалттай.

Гэвч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийхдээ компаний хөрөнгө, хувь нийлүүлэгчийн хөрөнгөөс зааглагдсан эсэхийг тогтоох ажиллагааг явуулахгүй байгаа жишээ олон би. Үүний нэг нь Сүхбаатар Дүүрэг /СБД/-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх /ИХАШШ/-ээс гаргасан шийдвэр юм. *Жишээ:* Иргэн А нь төлбөр төлөгч Б компаний 10 хувьтай тэнцэх 100 000 төгрөгийн үнэлгээ бүхий хувьцааг эзэмшдэг бөгөөд тус компанид үүссэн аливаа хариуцлагыг оруулсан хөрөнгө болох 100 000 төгрөгийн хүрээнд хүлээх ёстой юм. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад оруулсан хөрөнгийн хэмжээг үл харгалзан зөвхөн эзэмшиж буй хувь хэмжээгээр төлбөр барагдуулах ажиллагаа хийсэн байна[9]. Уг ажиллагааг хүлээн зөвшөөрөөгүй иргэн А шүүхэд хандан нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэлийг шүүх хүлээн авч СБД-ийн ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 6-р сарын 22-ны 181/ШШ2021/01269 тоот захирамжаар гуравдагч этгээдийн эрхийг хангасан байна. Өөрөөр хэлбэл Шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хууль хэрэглээний алдаа гаргасан хэмээн үзсэн юм. Үүний цаана төлбөр барагдуулах ажиллагаа удааширч 1 жил гаруй саатсан, төлбөр авагчийн эрх ашиг давхар хөндөгдсөн зэрэг үр дагавар бий болжээ.

---

[8] Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, https://legalinfo.mn/main/detail/310

[9] Сүхбаатар дүүргийн ИХАШШүүхийн 2021 оны 6-р сарын 22-ны 181/ШШ2021/01269 https://shuukh.mn/single_case/104382?daterange=2020-01-01%20-%202021-10-19&id=1&court_cat=1&bb=1

Энэ мэт гүйцэтгэх ажиллагааны явцад Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5 дахь заалтыг буруу хэрэглэж, гүйцэтгэлийн ажиллагаа хуулийн дагуу хийгээгүйн улмаас төлбөр төлөгч хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн өмчлөх эрхэнд халдах явдал гарсаар байна. Өнгөц харахад зөвхөн хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн хөрөнгөнд халдаж байгаа мэт боловч цаана нь тухайн этгээдийн гэр бүлийн гишүүдийн, дундын өмчлөлийн хөрөнгөнд давхар халдаж буйг үгүйсгэх аргагүй юм.

Дүгнэлт

Гуравдагч этгээд гэдэг нь онолын болон хууль зүйн тодорхойлолтоос харахад иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож буй төлбөр төлөгч, төлбөр авагчаас бусад эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд хэмээн тодорхойлж болно.

Гуравдагч этгээдийн хувьд иргэн, хуулийн этгээд гэсэн 2 субьект байгаа бөгөөд эрх нь зөрчигдөж байгаагийн хувьд харилцан адилгүй байна. Учир нь гуравдагч этгээд-иргэний хувьд Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад зөрчих, нөгөө талаас төлбөр барагдуулах ажиллагаа удаашрах, зогсох, түдгэлзэх, биелэгдэхгүй байх шалтгаан болж байна. Харин хуулийн этгээдийн хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Компанийн тухай хуулийг талууд нэг мөр ойлгох, зөв хэрэглэх хууль зүйн болон практик шаардлага бий болжээ.

Санал:

1. Хуулийг нэг мөр ойлгохийн тул шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ын хэрэгжилтийг ханган ажиллах
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын байрны тодорхойлолтод, ажлын үзүүлэлтэд, энэ талаар тусгах, хагас жил, бүтэн жилээр хуулийн хэрэглээний талаар шалгалт сорил авч мэргэжлийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.6 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ тус хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг баримталж буй нь дээрх дурдсан рүндрэлийг бий болгож байгаа

хуульд нэмэлт зохицуулалт хийж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 2020 он
2. Иргэний хууль. 2002 он
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он
5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2004 он
6. Гэр бүлийн тухай хууль. 1999 он
7. Компанийн тухай хууль.1999 он
8. Улсын дээд шүүхийн тогтоол. 2007 оны №27
9. Улсын дээд шүүхийн тогтоол. 2007 оны №43
10. Улсын дээд шүүхийн зөвлөмж. 2010 оны №2
11. Монгол Улсын дээд шүүхийн тайлан. 2020 он
12. С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. 4 дэх хэвлэлт, УБ хот. 2015 он.